



ДУНДГОВЬ АЙМГИЙН
САЙХАН-ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 07 сарын 04 өдөр

Дугаар А/156

Онги

Газар эзэмших эрхийн гэрчилгээний
хугацаа сунгах тухай

Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.16 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх заалт, 37 дугаар зүйлийн 37.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Сумын онги багийн нутаг дэвсгэрт Хадан хошуу 1-104 тоот-д байршилтай ХААН банкны салбар (2693321) –ны үйлчилгээний зориулалтай газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацааг 40 жилээр сунгасугай.

2. Газар эзэмших эрхийн гэрчилгээг шинэчлэн олгож, газар эзэмших гэрээ байгуулж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын мэргэжилтэн (Т.Саранзул)-д үүрэг болгосугай

3. Эзэмшил газраа байгаль орчинд сөрөг нөлөөгүйгээр зориулалтын дагуу эзэмшиж, газрын төлбөрөө цаг тухайд нь төлж байхыг газар эзэмшигч (Хаан банк)-д үүрэг болгосугай.

4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан газар эзэмших эрхийн 0075128 тоот гэрчилгээг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА

Г.ЛУВСАНРАГВА

